**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 07 сарын 22 өдөр Дугаар 308 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 54,544,545.00 (тавин дөрвөн сая таван зуун дөчин дөрвөн мянга таван зуун дөчин таван) төгрөгийн балансын үнэ, 2,762,695.35 (хоёр сая долоон зуун жаран хоёр мянга зургаан зуун ерэн таван төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан байгууллагуудад балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Монгол Улсын ерөнхий Аудитор Д.Занданбат, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Механик тээврийн сургуулийн захирал Д.Цолмонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТҮВШИНЗАЯА

0000555

C:\2019.07.22 16г huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 о
сарын 22 -ны өдрийн 308.. дугаар тогтоолын ха

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| ...н нэр | Ашиглалт тад орсон огноо | хэм жих нэгж | тоо шир хэг | Нэг бүрийн үнэ (төгрөгөөр) | Нийт үнэ (төгрөгөөр) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Үлдэгдэл өртөг (төгрөгөөр) | Х... б... |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ...уйдан | 1/1/2018 | ш | 1 | 754545 | 754,545.00 | 201,212.02 | 553,332.98 | Ау... |
| ...ирээ ...авилга/ | 1/1/2018 | ш | 1 | 130000 | 130,000.00 | 6,500.00 | 123,500.00 | Ау... |
| ..., тоног ...мж | 12/31/2018 | ш | 1 | 24380000 | 24,380,000.00 | - | 24,380,000.00 | I... |
| ...ейшн | 7/15/2018 | ш | 3 | 800000 | 2,400,000.00 | 160,000.00 | 2,240,000.00 | |
| ...хөөрөмж ...ster V3/ | 12/15/2017 | ш | 1 | 6,990,000.00 | 6,990,000.00 | 932,000.00 | 6,058,000.00 | |
| ...3 quot | 12/31/2018 | ш | 5 | 379,900.00 | 1,899,500.00 | 158,291.67 | 1,741,208.33 | |
| ... I3Dell ...3050 | 1/1/2019 | ш | 10 | 835,600.00 | 8,356,000.00 | 696,333.33 | 7,659,666.67 | |
| ... I3Dell ...3051 | 1/2/2019 | ш | 5 | 1,167,100.00 | 5,835,500.00 | 291,775.00 | 5,543,725.00 | |
| ...uot Dell | 1/3/2019 | | 10 | 379,900.00 | 3,799,000.00 | 316,583.33 | 3,482,416.67 | |
| | | | **37** | **35,817,045.00** | 54,544,545.00 | 2,762,695.35 | 51,781,849.65 | |
| ...ГИЙН ДҮН | | | **54 (тавин дөрөв)** | | **54,544,545.00 (тавин дөрвөн сая таван зуун дөчин дөрвөн мянга таван зуун дөчин таван)** | **2,762,695.35 (хоёр сая долоон зуун жаран хоёр мянга зургаан зуун ерэн таван төгрөг гучин таван мөнгө)** | **51,781,849.65 (тавин нэгэн сая долоон зуун наян нэгэн мянга найман зуун дөчин есөн төгрөг жаран таван мөнгө)** | |